ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
**ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/06 Амардалай

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлгэрцогт сумын 1 болон 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байршилтай 3 иргэний 4 байршлын нийт 20000 м.кв (2 га) өвөлжөө, хаваржааны зориулалттай газрын эзэмшигч иргэд нас барсан тул Өв шилжүүлэх хүсэлт өгсөн дараах иргэдэд уг газруудыг хавсралтаар өмнөх эзэмшигчийн газрын зориулалт, хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/16 тоот захирамжийн иргэн Ш.Жалцанд холбогдох хэсэг, 2018 оны 04 сарын 30-ны өдрийн Б/17 тоот захирамжийн иргэн Л.Цэрэндэжидэд холбогдох хэсэг, 2015 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/61 тоот захирамжийн иргэн Ц.Жамсранжавт холбогдох хэсэг мөн газар эзэмших 000051262 болон 000051266 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

ДАРГА М.БАЯРСҮХ

Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын
16 ны өдрийн А/06 тоот захирамжийн хавсралт

| № | Өмнөх эзэмшигчийн | | | | Өв шилжүүлэн авах эзэмшигчийн | | | | Газрын | | | Үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Нэр | Регистр | Нас барсан өдөр | Овог | Нэр | Регистр | Өмнөх эзэмшигчийн хэн болох | Баг | Нэр | Хэмжээ /м.кв/ | |
| 1 | Цэвээнжав | Жамсранжав | ЗЕ49083036 | 2021-11-13 | Хорлоо | Янжинлхам | ЗЕ58010507 | Эхнэр | 2 | Босго | 5000 | 1200000 |
| 2 | Цэвээнжав | Жамсранжав | ЗЕ49083036 | 2021-11-13 | Хорлоо | Янжинлхам | ЗЕ58010507 | Эхнэр | 2 | Хүрэн дэл | 5000 | 7000000 |
| 3 | Лувсан | Цэрэндэжид | ЗЕ40061503 | 2020-07-08 | Цэрэндэжид | Энхжаргал | ЗЕ73042302 | Охин | 1 | Сайн усны адаг | 5000 | 7000000 |
| 4 | Шадав | Жалцан | ЗЕ40090815 | 2021-11-20 | Авирмэд | Цэндсүрэн | ЗЕ45021803 | Эхнэр | 2 | Ар цагааны бууц | 5000 | 9000000 |